



УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2024 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/141

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3.1, 24.3.3 дахь заалт, 24.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 88 дугаар тогтоол, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалт, 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.14 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жанжин Д.Сүхбаатарын талбай, Төрийн ордныг тойрсон явган хүний зам, түшиц хана засварлах ажил (СБД, 6 дугаар хороо)-ын гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулан ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хотын тохижилтын хэлтэст үүрэг болгосугай.

2. Энэхүү тушаалын 1 дүгээр заалтад заасан ажилд шаардагдах 19,608,832 (Арван есөн сая зургаан зуун найман мянга найман зуун гучин хоёр) төгрөгийг Хот тохижилтын бусад зардлаас захиалагчийн хяналтын тайланг үндэслэн гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч (Б.Халиун)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын газар (Г.Билгүүн)-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Ц.ТӨРХҮҮ

